



**НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Лед гэрэлтүүлэгчтэй явган хүний гарц
болон чингэлэг бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хөрөнгөөр ерөнхий боловсролын 3 сургуулийн орчинд байршуулсан 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөгийн лед гэрэлтүүлэгчтэй явган хүний гарц болон Цэргийн албыг мөнгөн хэлбэрээр дүйцүүлэн хаах орлогоор худалдан авсан 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийн чингэлгийг хавсралтын дагуу холбогдох данс бүртгэлд бүртгэсүгэй.

2. Засаг даргын Тамгын газрын өмчид бүртгэгдэж буй эд хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Ерөнхий нягтлан бодогч (Т.Баршагул)-д, ажилтан, албан хаагчдын эд хөрөнгийн картад бүртгэж ажиллахыг Нярав (Л.Гантуяа)-т даалгасугай.


3. Бүртгэгдэж буй хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Д.Дэмчигжав)-т, Багануур гэрэлтүүлэг, чимэглэл ААТҮГ (Д.Батнасан)-т, Цэргийн штаб (З.Майдар)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



П.БАТТУШИГ

Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны
өдрийн 166 дугаар тушаалын хавсралт



Засаг даргын Тамгын газарт бүртгэгдэх хөрөнгийн жагсаалт

№	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ (төгрөг)	Тайлбар
1	Лед гэрэлтүүлэгчтэй явган хүний гарц	ш	3	6,600,000	19,800,000	Боловсрол цогцолбор сургууль, Гүн галуутай цогцолбор сургууль, Оюуны эрин цогцолбор сургууль
2	Чингэлэг	ш	1	7,500,000	7,500,000	20 тн
Нийт дүн					27,300,000	